**"ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2022.02.07

| Д/д | Хэрэгжилт | | Бүгд | Зорилтоор | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хяналтанд авсан зорилтын тоо | | **2** | Зорилт 1 | Зорилт 2 |
| 2 | Хяналтанд авсан арга хэмжээний тоо | | **18** | 6 | 12 |
| 3 | Үнээс | Үр дүнтэй буюу 100% | **16** | 5 | 11 |
| | | Тодорхой үр дүнд хүрсэн буюу 90% | **1** | | 1 |
| | | Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70% | **1** | 1 | |
| | | Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50% | **0** | | |
| | | Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30% | **0** | | |
| | | Үр дүнгүй буюу 0% | **0** | | |
| **Хэрэгжилтийн хувь** | | | **97.7%** | **98.33%** | **99.17%** |
| **Хэрэгжилтийн оноо** | | | **4.89** | **4.92** | **4.96** |

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Д.ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: МЭРГЭЖИЛТЭН Э.ХОНГОРЗУЛ

## "ДАРХАН-ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

2021.12.15 Дархан-Уул аймаг

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилт | Гүйц/ хувь | ХШҮДА хариуцсан ажилтны үнэлгээ | Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн Даргын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Стратеги төлөвлөгөөний зорилго №1** Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах ажлыг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж эхлүүлэх, батлагдсан зураг төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж гүйцэтгэлийг баталгаажуулах, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулж төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах. | | | | | |
| | Зорилт №1 Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дархан-уул аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээнд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж гүйцэтгэлийг барилга байгууламжийн норм нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянан | 1.1 Барилга байгууламж шинээр барих, өргөтгөх шинэчлэн засварлах 33 төсөл арга хэмжээ | 58 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлж ажилласан ба 252 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч биелэлтийг 95%-иас дээш хангуулан 89 лабораторийн сорил шинжилгээ хийлгэж ажлын явцыг 2357 фото зургаар баримтжуулж, үе шатны 273 ажлыг ил далд ажлын актаар баталгаажуулсан. | 100% | 95% | 95% |
| | | 1.2 Инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах 7 төсөл, арга хэмжээ | 12 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэн ажилласан ба 41 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч, биелэлтийг 100%-с дээш хангуулан 72 лабораторийн сорил шинжилгээ, хийлгэн, ажлын явцыг 415 фото зургаар баримтжуулан, ил далд ажлын 246 актыг баталгаажуулан, ажлын тоо хэмжээг тулган шалгаж 21 гүйцэтгэлийг баталгаажуулсан. | 100% | 100% | 99% |
| | | 1.3 Авто зам, зогсоол шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах 23 төсөл, арга хэмжээ | 44,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан ба 129 удаа зөвлөмж, үүрэг даалгаварыг өгч биелэлтийг 98%-иас дээш хангуулан 1346 цэгт түвшин шалгаж 483 цэгт нягт шалгаж, төсөл арга хэмжээний ажлыг явцыг 3246 ш фото зургаар баримтжуулсан ба үе шатны ажил эхлүүлэх 948ш рекуст баталгаажуулж, далд ажлын 398ш актыг баталгаажуулсан. | 100% | 98% | 98% |
| | | 1.4 Цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн нийт 5 төсөл, арга хэмжээ | 2,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээнд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж 22 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч, биелэлтийг 95%-иас дээш хангуулан 19 лабораторийн сорил шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн. Ажлын явцыг 368 ш фото зургаар баримтжуулан, үе шатны ажлуудад хэмжилт шалгалт хийж 108 ш актыг баталгаажуулсан. | 100% | 95% | 95% |
| | | 1.5 Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах **Мон 3244/3245** төслийн ажил | Пфайфер-ЭМИТ түншлэлийн гүйцэтгэж байгаа Мон 3244/3245 төслийн ажилд 32 барилга байгууламжийн угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналт | 90% | 90% | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | баталгаажуулах | | хэрэгжүүлж 98 удаа зөвлөмж даалгаварийг өгч, биелэлтийг [illegible] хувиас дээш хангуулан, 10 лабораторийн сорил шинжилгээ хийлгэн ил далд ажлын 61 актыг баталгаажуулж 228ш фото зургаар баримтжуулан барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж, гүйцэтгэлийг баримт бичгийн иж бүрдлийг хангуулан гүйцэтгэлийг баталгаажууллаа. Нийт төслийн ажлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 77% тай байна. | | | |
| | | 1.6 Гүйцэтгэлийн төсөв хянан баталгаажуулах | 2021 онд 32,0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулсан. Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангаж магадлашгүй ажил болон бусад хийгдээгүй ажлын зардлаас 163,6 сая төгрөгийг хэмнэлт үүсгэж ажилласан | 100% | 100% | 100%. |
| **Хэсгийн дүн** | | | | **98,3%** | **96,3%** | 96,1%. |
| **Зорилт №2 Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | | |
| 2 | 2.1 Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах, газрын сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулж ажилчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх | 2.1.1 Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах | 2021 оны батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан үндсэн 8 гэрээгээр 4 инженер ажилд аван нийт 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явууллаа. Бүтээн байгуулалтын ажилд багаар ажиллах, өөрчлөлтийг хүлээж авах, оновчтой шийдвэр гаргах мэргэжлийн ур чадвартай мэргэшсэн инженерүүдийг томилон ажиллуулж байна. | 100% | 100% | 100%. |
| | | 2.1.2 Сургалтын хэрэгцээг тодорхойлж, төлөвлөгөөний дагуу сургалтанд хамрагдах, сургалт зохион байгуулах. | 2021 оны байгууллагын батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу Барилгын инженер Б.Анхбаяр нь Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулж буй "Мэргэшсэн инженер" ийн 10 кредит багц цагийн сургалтад 14 хоног цахимаар хамрагдсан. Сантехникийн инженер Б.Гантуяа нь "Мэргэшсэн инженер"-ийн багц цагийн сургалтад 100% хамрагдсан. Бичиг хэргийн ажилтан А.Нарангарав нь Архивын ерөнхий газраас зохион байгуулсан "Архив-албан хэрэг хөтлөлт"-ийн сургалтад цахимаар хамрагдаж сертификатаа авсан. Авто замын инженер Д.Аюурзана нь Үндэсний Дата төвөөс зохион байгуулсан Вэб админ, вэб хуудас хөгжүүлэх сургалтад хамрагдсан. Мөн Авто замын хяналтын инженерийн сургалтад хамрагдаж сертификатаа авсан. Мөн ИТА, албан хаагчид нь ерөнхий инженерийн удирдлагаар "Нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль", Авилгын тухай хуулийн талаар танилцуулга болон "Барилгын зураг төсөл, угсралт, материал,технологи"-ийн шинэ мэдээллүүдээр хийсэн сургалтад хамрагдаж мэдлэг, мэргэшил ур чадвараа дээшлүүлсэн. | 100% | 95% | 95%. |
| | 2.2 Мэдээ тайлан гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх | 2.2.1 Мэдээ тайлан гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх | Аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хуралд долоо хоног бүрийн мягмар гаригт буюу нийт 34 удаа оролцон барилгын ажлын явцын талаар мэдээ тайланг | 100% | 100% | 100%. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргуулж байв. Барилга у[illegible]алт, засвар шинэчлэлт өргөтгөлийн 12[illegible] төсөл, арга хэмжээ бүрээр объектын тайлан гаргаж газрын мэдээллийн санг бүрдүүлж ажилласан ба тайланг хагас болон бүтэн жилээр гарган аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлэн ажилласан.<br>Мон 3244/3245 төслийн сарын ажлын төлөвлөгөө, тайлан, улирлын тайлан, жилийн эцсийн тайланг Дархан төслийн удирдах нэгжид сар бүр хугацаанд нь хүргүүлж ажилласан. Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулсан ба худалдан авах ажлын төлөвлөгөө, тайланг ОНӨГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Мөн 2020 оны гүйцэтгэлийн тайлан, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн. 2020 оны байгууллагын жилийн эцсийн тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид болон аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2021 оны 02 дугаар сард танилцуулсан.<br>Санхүүгийн ил тод байдлын мэдээг shilendans.gov.mn сайтад сар бүр гаргаж олон нийтэд мэдээлсэн. Мөн 2020 санхүүгийн тайланг гарган ЦЭСБ аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. 2021 оны жилийн эцсийн байдлаар 347 ш архивын хадгаламжийн нэгж газрын архивт хадгалагдаж байгаа ба 2020 оны жилийн эцсийн мэдээг аймгийн Архивын тасагт хүргүүлсэн. | | | |
| | | 2.2.1 Холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах | Аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хуралд долоо хоног бүрийн мягмар гаригт буюу нийт 34 удаа оролцон барилгын ажлын явцын талаар мэдээ тайланг хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан. Мон 3244/3245 төслийн сарын ажлын төлөвлөгөө, тайланг Дархан төслийн удирдах нэгжид сар бүр хугацаанд нь хүргүүлж ажилласан. 2020 оны байгууллагын гүйцэтгэлийн тайлан, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн. 2020 оны байгууллагын жилийн эцсийн тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид болон аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2021 оны 02 дугаар сард танилцуулсан. Мөн 2020 санхүүгийн тайланг гарган ЦЭСБ аудитаар баталгаажуулан аймгийн татварын хэлтэс, санхүү төрийн сангийн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн. | 100% | 100% | 100% |
| | 2.3 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах. Мэдээллийн ил тод байдлыг хангаж | 2.3.1 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах. | Аймгийн Мэдээлэл технологийн албатай хамтран ажиллаж бүтээн байгуулалтын ажлын явцын талаар фото болон дүрст мэдээ, сурвалжилга, шууд дамжуулалт нийт 45-ыг бэлтгэн цахим сүлжээн дэх албан ёсны фэйсбүүк, фэйж хуудсууд болон өөрийн байгууллагын вэб хуудас, фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн | 100% | 100% | 100/. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажиллах. | | ажилласан. Байгууллагын da.barilga.gov.mn вэб хуудас, Дархан хо[illegible]байгуулалт, барилга захиалагчийн газар цахим хуудсаар мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргүүлэн ажиллалаа. Байгууллагын фэйсбүүк хуудаст байршуулсан барилга угсралтын төсөл, арга хэмжээний мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор 63943 хүн харсан ба 1001 хүн дэмжин, 1021 хүн дагасан үзүүлэлттэй байна. | | | |
| | 2.4 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | 2.4.1 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | Салбарын хууль, тогтоомж, захирамж, тогтоол, тушаал, шийдвэр, дүрэм, журам, зааврыг дагаж мөрдөн ажилласан. Хууль тогтоомжийг үндэслэл болгон Даргын А тушаал 96 ш, Б тушаал 31 ш гарган мөрдөж ажилласан. 2021 онд байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 408 албан бичиг хүлээн авч бүртгэн хариутай бичгийг 100% хугацаанд нь шийдвэрлэсэн. 509 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан. | 100% | 98% | 100% |
| | 2.5 Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах. | 2.5.1 Төсвийн төлөвлөгөө боловсруулж батлуулан үйл ажиллагаа явуулах. | 2021 оны батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаа явуулсан. Нийт үйл ажиллагааны зардалд 200,6 сая төгрөг зарцуулсан. | 100% | 100% | 100% |
| | | 2.5.2 Газрын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж аудитын дүгнэлтээр баталгаажуулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх | 2020 оны жилийн эцсийн тайлан ЦЭСБ аудит ХХК-иар баталгаажуулан төрийн аудитын газраас зөрчилгүй санал дүгнэлттэй. Санхүүгийн тайлан, мэдээг | 100% | 100% | 100% |
| | | 2.5.3 Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулах. | 2021 онд борлуулалтын орлогыг 115%-иар бүрдүүлсэн ба үйл ажиллагааны зардалд 200,6 сая төгрөгийг зарцуулсан. Нийт 13,7 сая төгрөгийн өрийг барагдуулан, аймгийн төсөвт цэвэр ашгийн 25% иар буюу 8,0 сая төгрөгийн ноогдол ашиг төвлөрүүлсэн. | 100% | 100% | 100% |
| | | 2.5.4 Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах | Газрын 2021 оны санхүүгийн төсөв, төлөвлөгөөний дагуу бараа материал, шатахууны талон худалдан авч анхан шатны баримтыг үндэслэн орлогод аван шаардах хуудас болон шатахуун олгох хуудсыг үндэслэн ажилтнуудад олгосон. 2021 оны 05 дугаар сарын 18 ны өдрийн Дархан-Уул аймгийн орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу манай байгууллага дээр 2021 оны 06 дугаар сарын 07 нд аймгаас комисс томилогдон ирж тооллого зохион байгуулсан. Тооллогоор дутсан, илүүдсэн хөрөнгө байхгүй. Нийт 73,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдсон.<br>Мөн Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 31 ний өдрийн 01-А/163 тоот захирамжаар 7 төрлийн 4,163,632 төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсны дагуу байгууллагын өмч | 100% | 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хамгаалах зөвлөл нь хуралдан үндсэн хөрөнгийг актлан тайланг ОН[illegible]-т хүргүүлсэн.<br>2021 онд байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь нийт [illegible] удаа хуралдан холбогдох шийдвэрүүдийг гарган газрын Даргад танилцуулж ажиллалаа.<br>Шатахуун худалдан авах тендерийг газрын Даргын 2021.01.15 ны өдрийн А/02 тоот тушаалын дагуу зохион байгуулсан ба 2 оролцогч оролцож Сод монгол групп шалгарч 2021 оны 3 р сарын 10-нд 11,672,000 төгрөгийн "Шатахуун худалдан авах гэрээ"-г байгуулсан. Хагас болон бүтэн жилээр үндсэн хөрөнгийн тооллого зохион байгуулсан. | | | |
| | 2.6 Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төсөл засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдлийн удирдлагаар хангах. | 2.61 Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах | Улсын комиссоор ашиглалтад оруулсан барилга байгууламжуудад гарсан зөрчлийг ашиглагч байгууллагуудаас ирсэн гомдол, саналыг үндэслэж гүйцэтгэгч байгууллагуудаар баталгаат хугацаанд нь засварлуулах ажлыг хяналт гүйцэтгэж байсан инженерүүдээр хариуцуулан гүйцэтгүүлж байна. Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас 2019, 2020 оны үйл ажиллагаа, үр дүнд аудитын шалгалт хийсэн ба аудитаар илэрсэн барилга угсралтын зөрчил дутагдлуудыг арилгуулах арга хэмжээ авсан. Мөн аудитын актаар тогтоосон төлбөр болох 1,711,689 төгрөгийг хугацаанд нь төлж барагдуулсан. | 100% | 98% | 97% |
| | | 2.6.2 Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулан батлуулж холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлэх. | 2020 оны газрын үйл ажиллагааны тайлан, 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг холбогдох аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хугацаанд нь хүргүүлсэн ба 2021 оны 02 дугаар сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХ-ын төлөөлөгчдөд 2020 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулсан. Газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан. Инженер техникийн ажилтан, албан хаагчид нь 2021 онд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлсэн объект тус бүрээр тайланг гарган газрын мэдээллийн санг үүсгэн ажилласан ба эхний хагас жил, бүтэн жилийн тайланг Аймгийн ЗДТГ ын ХОХБТХ-т хүргүүлсэн. | 100% | 100% | 100% |
| Хэсгийн дүн | | | | 100% | 99.2% | 99.3% |
| **Нийт дүн** | | | | **99,1%** | **97,7%** | 97,7% |

**Санал дүгнэлт, зөв  эмж:**

"ДХББЗГ" ОНӨААТҮГ нь 2021 онд 77 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө гарган ажилласан ба жилийн эцсийн байдлаар 2020-2021 онд шилжсэн 12 төсөл, арга хэмжээ шинээр 112 төсөл арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлж гүйцэтгэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байна.

Зорилт №1 стратеги төлөвлөгөөний 6 арга хэмжээ, Зорилт №2 стратеги төлөвлөгөөний 12 арга хэмжээнд буюу удирдлагын үйл ажиллагаа, инженерүүдийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд тус тусад нь үнэлэхэд нийт үнэлгээгээр 97,7% тай буюу ХАНГАЛТТАЙ гэж дүгнэв.

*Цаашид анхаарах асуудлын хувьд:*

1. Төслийн ажил гүйцэтгэх графикийн хугацааг бодитойгоор тооцох.
2. Ажил эхлэхийн өмнө зураг, төслийн судалгааг сайн хийж тодорхойгүй асуудлуудыг шийдвэрлэх.
3. Техникийн тодорхойлолтод заагдсан материал, хийцүүдийг ажил гүйцэтгэх үед тулгаж шалгах.
4. Улсын комисс хүлээн авсны дараа ашиглагч байгууллагаас гомдол, санал ирүүлсэн тохиолдолд төсөл, арга хэмжээний баталгаат хугацааны засварыг цаг алдалгүй хугацаанд нь засварлуулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажилтан:
Ерөнхий инженер /Ч.Батбулган/

Танилцаж зөвшөөрсөн:
Дарга /Д.Батбаяр/

Үнэлгээ хийсэн:
Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн Дарга /П.Батсүх/